

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ2022 оны 07 сарын 22 өдөрДугаар: 15

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолд заасны дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах компанийн жагсаалтад багтсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.


2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 22 ны өдрийн 15 дугаар тогтоолын ХАВСРАЛТ



**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦААГ
ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАМЖУУЛАН АРИЛЖААЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөгөөний үе шат	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					
			2022 7-8 сар	2022 9-11 сар	2022 12 сар	2023 1-2 сар	2023 2-4 сар	2023 4-7 сар
1.	Бэлтгэл үе шат	Ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулах	+					
		Үнэт цаасны мэргэжлийн оролцогчдыг сонгоход баримтлах дотоод журмыг боловсруулж батлуулах	+					
		Үнэт цаасны мэргэжлийн оролцогчдыг сонгож, үйлчилгээний гэрээ байгуулах	+					
		Компанийн засаглалын багц журмуудыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөх		+				
2.	Магадлан шинжилгээний үе шат	Санхүүгийн магадлан шинжилгээ		+				
		Хуулийн магадлан шинжилгээ		+				
		Хөрөнгийн үнэлгээний тайлан боловсруулах		+				
		Үнэт цаасны бүрдүүлбэрийг тодорхойлох		+				
		Үнэт цаасны дэлгэрэнгүй, хураангуй танилцуулга бэлтгэх		+				
		Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлийн журамд тус тус заасан мэдүүлэг, дүгнэлтүүдийг бэлтгэх		+				
		Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдэхэд хувьцааны ханшийн уналтаас сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулах, холбогдох судалгааны ажлыг гүйцэтгэх;		+				
3.	Эрх бүхий этгээдийн бүртгэлд бүртгүүлэх үе шат	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх хүсэлт, хавсралт баримт бичгийг хүргүүлэх			+			
		Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн хяналт, зөвшөөрөл				+		
4.	IPO хийх үе шат	Үнэт цаасны танилцуулгыг олон нийт, стратегийн хөрөнгө оруулагчдад хүргэх, танилцуулах					+	
		Арилжааны захиалгын бүртгэл, анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийн бүртгэлийг бүртгэх					+	
		Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцуулах, Хоёрдогч зах зээлийн арилжааг нээх						+
		Нээлттэй ХК болсны дараах зохион байгуулалтын арга хэмжээг гүйцэтгэх						+